

**АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН
ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ**

ЭЕШ ГЭЖ ЮУ ВЭ?

ЭЕШ нь жил бүр Монгол Улсын хэмжээнд тухайн жилд болон өмнөх жилүүдийн төгсөгчдийг их, дээд сургуулиудад элсүүлэх зорилгоор авдаг шалгалт юм. Шалгалтын оноог 200-800 оноогоор дүгнэх бөгөөд сургууль бүр өөрийн босго оноог зарладаг. ЭЕШ дүнг Боловсролын Үнэлгээний Төвөөс гаргасан тусгай аргачлалаар тухайн шалгуулагчийн гүйцэтгэлд тохирсон анхны оноо, хэмжээст оноо, процентал оноо гэх гурван оноогоор дүгнэдэг. Бидний сайн мэдэх ЭЕШ-ын хамгийн өдөр оноо болох 800 оноо нь хэмжээст оноо юм. Энэхүү 800 оноог тогтоохдоо тухайн жилд шалгалт өгсөн нийт төгсөгчдийн гүйцэтгэлийг харгалзан үздэг.

ЭЕШ-ийн босго оноо гэж юу вэ?

2019 онд их, дээд сургуулиудад элсэх босго оноог Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 480-аас багагүй байхаар тогтоосон. ЭЕШ өгч буй нийт шалгуулагчдын 60% нь уг босго оноог авах боломжтой бөгөөд эрэлт ихтэй их, дээд сургуулиудын босго оноо илүү өндөр байх магадлалтай. Мөн нийт шалгуулагчдын 10 хүрэхгүй хувь нь 700-аас дээш оноо авах боломжтой ба 3 хүрэхгүй хувь нь 800 оноонд хүрэх боломжтой байдаг. Тиймээс хүссэн сургуульдаа сурахын тулд ЭЕШ-даа шаргуу бэлдэж өндөр оноо авах шаардлагатай.

ЭЕШ-д хэрхэн өндөр оноо авах вэ?

Суурь мэдлэг: Ямар ч шалгалт хэн бүхний мэдлэгийг шалгах зорилготой. Хэрэв тухайн сэдвийн агуулгыг сайтар эзэмшээгүй бол хэчнээн хүсэл байсан ч өндөр оноо авах үндэслэл байхгүй болно. Суурь мэдлэгийг бат эзэмшсэнээр ЭЕШ төдийгүй гадаадын ижил төстэй шалгалтуудыг амжилттай давах гол хүчин зүйл болдог.

Хурд: Шалгалт бол гэрийн даалгавар биш. Гэрийн даалгаврыг тодорхой цагийн хязгаарлалтгүй хийдэг ч шалгалт нь цагтай уралдан тухайн асуудлыг шийддэг гэдгийг санаарай. Хэдий даалгавраа сайн хийдэг байлаа ч энэ нь өндөр оноо авах баталгаа болж чадахгүй, ХУРД зайлшгүй хэрэгтэй. Тиймээс цагтай байнга ажиллах хэрэгтэй.

Арга барил: Шалгалтын бүтэц, асуултын хэлбэрийг сайтар судалж цагаа зохицуулах нь амжилт гаргах бас нэгэн чухал түлхүүр болдог. Өөрийн хамгийн сайн чадах даалгавраас эхлэх хэрэгтэй. Энэ нь чамд цаг хугацаа хэмнэх маш том боломж олгодог төдийгүй тухайн үеийн сандрал тодорхой хэмжээгээр багасдаг.

Англи хэлний ЭЕШ бол өөрийнхөө үндсэн хэлээр биш учраас бусад шалгалтуудаас нилээн хүнд байгаа. Тийм болохоор хүүхдүүдэд мэдээж мэргэжлийн хүний туслалцаа зайлшгүй шаардлагатай. Ямар ч шалгалтанд шалгалт өгөх стратеги, цаг төлөвлөлт, дадлага хийх нь зайлшгүй. Англи хэлний ЭЕШ-нд бэлдэхдээ зөвхөн дүрэм гээд зогсохгүй хэлний бодит хэрэглээ, үгийн сангийн хэрэглээ, унших чадвар дээрээс нь өвөрмөц үг хэллэг, ижил утгатай үг хэллэг сурах, өгүүлбэрийн алдааг олох дасгал, үгийн сонголтыг зөв хийх, текстэнд тохирсон үгийг дүрмийн дагуу нөхөх, график, зар тэмдэглэгээг ойлгох чадварууд гэх мэт онцлогтой даалгаварууд багтаж байгаа.

Хэл гэдэг бол хэдхэн хоног, сарын асуудал биш учир шалгалтанд амжилттай бэлдэхийн тулд нилээдгүй хугацаанд ул суурьтайгаар системтэй бэлдэж шалгалтанд өөртөө итгэлтэй, шалгалтын стратеги, цаг төлөвлөлттэй орвол өндөр оноо авч чаднаа.

Элсэлтийн ерөнхий шалгалт жил бүр өөрчлөгддөг. Жил бүрийн шалгалтын материал дээр анализ хийж үзэхэд англи хэлний ЭЕШ эхний жилүүдэд дүрэм болон сонгох дасгалууд голчлон байдаг байсан бол одоо дүрмийг хэрэглээтэй нь холбосон үгийн сан, унших чадварыг шалгах даалгаварууд давамгайлж байна.